



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2017 оны 03 сарын 18 өдөр

Дугаар 41

Номгон

“Эрхэт хайрхан” уулыг аймгийн
тахилгат уул болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх заалт, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 117 дахь заалт, аймгийн Нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн 106 дахь заалт, Эрдэнэцогт сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 07 дугаар тогтоолыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Эрдэнэцогт сумын Эрхэт хайрхан 5 дугаар багийн нутагт орших далайн түвшинээс дээш 3535 метрийн өндөрт өргөгдсөн Монгол орны Хангайн нурууны хоёр дахь ноён оргил “Эрхэт хайрхан” уулыг аймгийн тахилгат уул болгох саналыг дэмжсүгэй.

2. Тахилгын ёслолыг аймгийн хэмжээнд “Их богд” уулыг тахих журмын дагуу 2 жил тутамд зохион байгуулсугай.

3. “Эрхэт хайрхан” уулын тахилгын ёслолыг аймгийн хэмжээнд зохион байгуулж тодорхой тов тогтоон, төлөвлөгөө гарган ажиллахыг аймгийн Засаг дарга /Г.Батжаргал/-д үүрэг болгосугай.

4. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /С.Үнэнбуян/-д даалгасугай.

ДАРГА



Ц.ОТГОНБАЯР

116747